

1911 ОНЫ ХУВЬСГАЛЫН 85  
ЖИЛИЙН ОЙД

**МОНГОЛ-ХЯТАДЫН ЦАГААГЧИН ГАХАЙ  
ЖИЛИЙН (1911 ОНЫ) ХУВЬСГАЛЫН  
НИЙТЛЭГ БА ЯЛГААТАЙ ТАЛ**

*Хэрээд Л.Жамсран\**

1911 онд Манж Чин улсын феодалын эзэн хаант төрийг түлхэн унагаж Монгол, Хятад хоёр орон тусгаар тогтнож, өөрсдийн төрийг байгуулсан хоёр хувьсгал нийтлэг ба ялгаатай ямар талтай байсныг авч үзэх нь сонирхолтой. Иймд өөрийн судалгаанаас үндэслэн дараах хэдэн зүйлийг толилуулъя.

*Нэг. Монгол, Хятадын хувьсгалын нийтлэг тал*

1. Монгол, Хятадын цагаагчин гахай жилийн хувьсгалын нийтлэг тал нь юуны урьд энэ хоёр хувьсгал бол хоёр зуу гаруй жил Манж Чин улсын хэмжээгүй эрхт хаант төрийн захиргаанд байж эсэргүүцэн тэмцсээр ирсэн Монгол, Хятад ард түмнүүдийн үндэсний эрх ашгийн илэрхийлэл болон гарч ялаад тус тусдаа түр боловч тусгаар тогтнож өөрсдийн төрийг байгуулсны хувьд хоёулаа нийтлэг зорилттой байсан.

2. XIX зууны дунд үеэс хэрэг дээрээ хагас колони болон хувирч байсан Чин улсын нийгэм улс төрийн хөрсөнд энэ хоёр хувьсгалын үр хөврөл нь үүсэн боловсорч биежсэн.

3. Монгол, Хятадын хувьсгалын аль аль нь Манжид эзлэгдэхийн өмнөх өөрсдийн төрийн тусгаар тогтнолоо сэргээх зорилт тавиад түүнийгээ зэвсэгт тэмцэлээр хэрэгжүүлэхийг хичээж байсан.

4. Чин улсын ноёрхлыг түлхэн унагааж өөрсдийн тусгаар тогтнолыг сэргээхийн төлөө тэмцэгч хувьсгалчид, Чин улсын нутаг дэвсгэрийн аль нэг хэсэгт эрх ашгаа бататгахыг хичээж байсан хүчирхэг гадаад орнуудын засгийн газар эсвэл дэвшилт олон нийтийн хамгаалал дэмжлэгээр ил далд өөрсдийн хувьсгалт үйл ажиллагааг явуулж байв.

5. Монгол, Хятадын хувьсгалчид өөрсдийн тусгаар тогтнолын үйл ажиллагаагаа амжилттай эхэлмэгцээ Чин улсын Хаант төрийн оны цолыг халж тус тусын оны цолыг зарласан зэрэг нийтлэгтэй байв.

*Хоёр. Монгол, Хятадын хувьсгалын ялгаатай тал нь*

1. Чин улсын гол цөм болж байсан Хятад оронд худалдаа, үйлдвэр хөгжиж, ажилчин анги, хөрөнгөлөг этгээд үүсч хөлжихөд нь Чин улсын феодал ёсны дэглэм саад болж байсан тул тариачид хийгээд нийгмийн шинэ харилцааны нахиа болж байгаа хүчнүүд өөрсдийн хувьсгалт нууц байгууллагуудыг байгуулж Манжийн хаант төрийг устгаж оронд нь ардчилалыг дэлгэрүүлж Хятадын хөрөнгөтний бүгд найрамдах төрийг байгуулах зорилготой хувьсгал хийсэн нь нэг талаар нийгмийн хувьсгалын шинжтэй, нөгөө талаар харийн ноёрхлыг устгаж үндэсний улсаа байгуулах гэсний хувьд үндэсний буюу эрх чөлөөний хувьсгалын шинжтэй байлаа. Түүний тэмцлийн анхны мөрийн хөтөлбөрт монголчуудын эсрэг заалтууд орсон байлаа. Тэр нь XIX зууны сүүлчийн хагасаас Монгол орон, Хятад ба харь орнуудад нээлттэй байх болж хятад иргэд, худалдаачид их олширсноос гадна XX зууны эхнээс Чин улсын төрийн зөвшөөрснөөр ашигт малтмалын уурхай, төмөр зам, үйлдвэр, үйлчилгээний газрууд гэх мэтийн хөрөнгөтөн орнуудын оролцоотой байгуулсан цөөн аж ахуй бий болсон бөгөөд тэнд ажиллагчид нь их төлөв гадаадын хүмүүс болон

\*Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, дэд доктор

хятадууд байсанд монголчууд дургүйцэж байсныг улам даамжруулав. Монголд ажилчин анги, үндэсний хөрөнгөтөн этгээд бий болоогүй байсан. Иймээс Монголын тусгаар тогтнолыг сэргээхийн төлөө тэмцлийг санаачлан зохион байгуулагчид нь феодал ангийн сэхээрсэн зарим зүтгэлтнүүд байлаа. Тэд Монгол орныг нөлөөнийхөө хүрээнд хуваарилсан орнуудаас хамгаалал тусламж олох, олон монголчуудын үндсээ мэдрэх чадавхийг сэргээн дайчлах замаар төрийн тусгаар тогтнолоо сэргээх зорилготой үндэсний хувьсгалыг үүсгэн зохион байгуулсан, тэгэхэд нүүдэллэн ирж байгаа иргэдээс бэлчээр нутгаа хамгаалах, хятад худалдаачдын мөлжлөгийг эсэргүүцсэн монгол малчин ард, хотын оршин суугчдын аяндаа хийж байсан түгээмэл тэмцэл нь уг хувьсгалын дэвсгэр болсон юм.

2. Хятадын хувьсгалчид, анхны мөрийн хөтөлбөртөө заасанчлан харь угсаатныг үлдэн зайлуулах биш харин Чин улсын төрийг устгаад, түүний ноёрхолд байгаа олон угсаатныг оршин суугаа нутаг дэвсгэртэй нь. Дундад Иргэн Улсын захиргаанд оруулж хөрөнгөт ёсны их гүрэн болгохыг хичээж байхад, монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгчид, Чин улсын ноёрхолд байгаа бүх монголчуудаа бүрэн хамарсан шашин төрийг хослон барьсан феодал ёсны хаант Монгол улс байгуулахын төлөө тэмцсэн.

3. Хятадын хувьсгалчид 1905 онд Түнмэнхүй гэдэг нэгдсэн эвлэл болон нэгдсэн хувьсгалт байгууллагатай болоод хувьсгалаа удирдсан. Гэтэл Монголд тийм хувьсгалт байгууллага байгаагүй. Харин Чин улсын шинэ засгийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байсан эх оронч зарим ноён, дээд лам нар уг бодлогыг эсэргүүцэж 1911 оны 11 дүгээр сарын сүүлчээр “Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар” гэдэг түр засгийн газрын шинжтэй байгууллага бий болгож Монгол улсын засгийн газар байгуулагдтал ажиллаж Ар Монголын Их Хүрээнээс манжийн захиргааг хөөн зайлуулах хувьсгалт эргэлтийг зохион байгуулж байсан. Хятадын хувьсгалч нарт Сүн Ятсений “Ардын гурван зорилт”-оор томъёологдсон хөрөнгөтний ардчилсан шинжтэй мөрийн хөтөлбөр байсан. Гэтэл Монголчууд Богд Жибзундамба хутагтын удаа дараагийн лүндэнд томъёологдсон хуучин руугаа илүү хандсан мөрийн хөтөлбөртэй байсан нь тэдний ангийн бүрэлдэхүүн тусгаар тогтнох зорилтоос нь урган гарсан юм.

4. Олон нийтийн хөдөлгөөн Өмнөд Хятадад хүчтэй өрнөж байхад 1911 оны 10 дугаар сарын 10-нд Хүбэй мужийн төв Учан-д хотын шинэ цэрэг, хувьсгалчдын удирдлагаар тус хотын оршин суугчдын дэмжлэгтэйгээр зэвсэгт бослого гаргасан нь Хятадын хувьсгалын эхлэл байсан бөгөөд түүний дараа өмнөд Хятадын олон муж Чин улсаас тусгаар тогтнохоо зарлаж байдал нэн хүндэрсэн үед, хувьсгалт мужуудын төлөөлөгчдийн хурал 1911 оны 12 дугаар сарын 29-нд Нанжин хотод болж Сүн Ятсенийг түр ерөнхийлөгчөөр сонгож үүрэгт ажилд нь оруулсан. Бас ДИУ-ын түр засгийн газар ба улсын хурлыг албан ёсоор байгуулсан. 1912 оны 2 дугаар сарын 12-нд хувьсгалт хүчний шахалтаар Чин улсын сүүлчийн эзэн хаан ширээнээсээ огцорч феодалын эзэн хаант төр эцэслэв. Энэ бол Хятадын хувьсгалын ялалт мөн.

Яг энэ үеэр буюу 1911 оны 12 дугаар сарын 29-нд монголын дээд ноёд, лам нарын хуралдаан болж монгол тусгаар тогтносныг тунхаглаж

Ар Монголын шарын шашны тэргүүн Жибзундамба хутагтыг олноо өргөгдсөн Монгол улсын шашин төрийг хослон баригч хаанаар өргөмжилж, Монгол улсын засгийн газрыг байгуулж, феодал ёсны төрийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн нь үндэсний хувьсгалын эхний ялалт мөн. Тулгар сэргэсэн Монгол улс, Чин улсын ноёрхол дахь олон Монгол угсаатныхаа нутаг орныг чөлөөлж өөртөө нэгтгэхийн тул уриалах, шаардах, зэр зэвсэг, цэргийн хүчээр туслах зэрэг олон аргыг хослон хэрэглэж байлаа.

5. Хятадын хувьсгалыг удирдсан хөрөнгөтөн ангийн этгээд сул доройн улмаас феодализм ба империализмтай эвлэрэнгүй байр суурьтай байсан, ард түмний хүчний дайчлан хөдөлгөж чадаагүй юм. Иймд Сүн Ятсен империализм, феодализмын хүчний шахалтаар 1912 оны 1 дүгээр сард түр ерөнхийлөгчийн тушаалаа, газрын эзэн, зууч ангийн төлөөлөгч Юань Шикайд алдсанаар Хятадын хувьсгал ялагдах замдаа орсон, Юань Шикай эхлээд түр, дараа нь жинхэнэ ерөнхийлөгчөөр сонгогдоод, үндсэн хууль, улсын хурлыг үл хайхрах явууллага хийсэн тул түүнийг эсэргүүцсэн олон нийтийн хөдөлгөөн өрнөж эхлэхэд, Сүн Ятсен “хоёр дахь хувьсгал” гаргахыг уриалан дуудаж 1913 оны зун тэмцэлдсэн боловч ялалтанд хүрч чадалгүй мон оны намар Сань Шикайн цэрэгт дарагдаж. Хятад орон бас л империализм, феодал цэргийн эрхтнүүдийн дарлалд үлдсэн боловч цагаагчин гахай жилийн хувьсгалын ач холбогдол нь феодалын эзэн хаант төрийн удаан ноёрхлыг эцэс болгож Хятад орны ардчилал, нийгмийн дэвшлийн замд оруулсанд оршино.

Юань Шикай Хятадын хувьсгалын зэрэгцээгээр Монголын хувьсгалыг дарах явууллагаа 1912 оны намраас буюу, Ар Монголын нутаг бүрэн чөлөөлөгдөөд, Өвөр Монголыг чөлөөлөх явдал ээлжит зорилго болсон үеэс нэн идэвхжүүлж, Монгол улсын эрх баригчдыг шууд ба шууд бус замаар ятгаж ухуулах, сүрдүүлэх, дээрэнгүйлэх өнгө аястай улс төрийг арга хэрэглэснээс гадна Өвөр Монголыг чөлөөлөхөөр 1913 оны эхээр хөдөлсөн, Ар, Өвөр Монголын нэгдсэн цэргийг, хүчээр цохих байлдаан хийсэн. ДИУ, Хаант Орос улс хоёр монголын асуудлаар удаан хэлэлцсэний эцэст 1915 онд гурван этгээдийн хэлэлцээр гэгчээр Монголын тусгаар тогтнолыг цуцлаж, зөвхөн Ар Монголыг ДИУ-ын харъяанд автономит эрхтэй байлгах тодий болгож Монголын үндэсний хувьсгалыг дарсан билээ.

6. Монгол, Хятадын цагаагчин гахай жилийн хувьсгалын бас нэг ялгаатай тал бол үргэлжилсэн хугацаа нь юм. Хятадынх 1911-1913 онд, Монголынх 1911-1915 онд тус тус үргэлжилж байгаад дарагдсан юм.

Монголын хувьсгалын ялалт нь түр боловч, төрийн тусгаар тогтнолыг сэргээж, монголчуудын үндэсний ухамсрыг асар их дээшлүүлж сэргэн мандалтын эхийг тавьсан. Түүнээс хойш аль ч газрын монголчууд үндэснийхээ эрхийн төлөө цөхрөлтгүй тэмцэх болсонд түүний ач холбогдол, түүхэн сургамж оршино.

Монгол, Хятадын хувьсгал нь нийтлэг зорилгогүй байсан учраас нэгдмэл удирдлагатай байгаагүй. Гэхдээ хоёр оронд болж байсан хувьсгалт үйл явдал харилцан нөлөөтэй байсан. Миний дээр дурьдсан зүйлүүд Ар Монголын тусгаар тогтнол нь Хаант Оросын тухиралт биш, харин монголчуудын өөрсдийнх нь хүсэл эрмэлзлэл, тэмцлийн үр дүн байсныг нотлож байна.